

Хүн амын эрүүл мэндийг дэмжихэд Төр, хувийн хэвшлийн түншлэлийн оруулах хувь нэмэр

Удиртгал

Төр, хувийн хэвшлийн түншлэл нь эрүүл мэндийн салбарт түгээмэл ухагдахуун болсон ч хамтран ажиллаж буй хувийн хэвшлийн бүтээгдэхүүн үйлчилгээний үр ашгийг нотлох нотолгоо хангалтгүй байна. Цаашлаад хувийн хэвшлийн бүтээгдэхүүн үйлчилгээ нь эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлсэн бол гарах ашиг сонирхлын зөрчлийг арилгахад хүндрэлтэй байж болох талаар Испанийн Нийгмийн эрүүл мэндийг хамгаалах нийгэмлэгийн судлаачид судалсан байна.

Энэхүү судалгааны зорилт нь эрүүл мэндийг дэмжих зорилгоор төр, хувийн хэвшил хамтарч ажиллах үйл явц, түүний үр өгөөжийг тодорхойлох, төр, хувийн хэвшлийн түншлэлийн үнэлгээнд тэдгээрийн онцлог шинж, ашиг сонирхлын зөрчил хэрхэн нөлөөлж байгааг задлан шинжилсэн.

Судалгааны товч танилцуулга

Төр, хувийн хэвшлийн харилцаа нь эрүүл мэндийн салбарт түгээмэл үзэгдэл болсон. Засгийн газар, хоёр талт институцууд, үйлдвэрийн газрууд нь эрүүл мэндтэй холбоотой нарийн төвөгтэй асуудлуудыг шийдвэрлэхдээ ийм төрлийн хамтын ажиллагааг хэрэгжүүлж байна.

Дэлхийн хэмжээнд Төр, хувийн хэвшлийн түншлэлийн гарал үүсэл, хамрах хүрээг нарийн тодорхойлсон байдаг бөгөөд олон судлаачид түүнийг нь хүлээн зөвшөөрдөг. НҮБ-ын “Тогтвортой хөгжлийн зорилтууд-2030”-ын 17 дахь зорилтод улс орнуудад “Түншлэлийн хүрээнд олж авсан туршлага, хөрөнгө мөнгөө зарцуулсан бодлогод түшиглэн төр, төр-хувийн хэвшил болон иргэний нийгмийн үр дүнтэй түншлэлийг хөхүүлэн дэмжиж, төлөвшүүлэх” –ийг уриалсан заалт бий.

Төр, хувийн хэвшлийн түншлэлийг дэмжсэн аргууд нь: эрүүл мэндийн ноцтой чухал асуудлуудыг шийдэхэд төр ганцаараа хангалтгүй; нийтийн эрүүл мэндийн үйлчилгээний чадамж, чанар, хүртээмжийг баяжуулах ажлыг төр, хувийн хэвшлийн түншлэл гүйцээдэг; түншилснээр эрүүл мэндийн асуудлыг бүх салбарын бодлогод оруулах боломжтой; өөрийгөө зохицуулдаг зохицуулалтыг сайжруулна; мөн бүтээгдэхүүн үйлчилгээний загвар, агууламжийг илүү эрүүл мэндэд ээлтэй болгох тогтвортой хөгжилд чиглэлийг бизнес загварыг баримталдаг зэрэг болно.

Хэдий ийм боловч эрүүл мэндийн салбар дахь төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай шүүмжлэлүүд байнга гардаг. Төр, хувийн хэвшлийн түншлэлд оролцсон хувийн байгууллагын нийлүүлсэн бүтээгдэхүүн үйлчилгээ нь эрүүл мэндэд сөргөөр нөлөөлсөн тохиолдолд тухайн хохирлыг барагдуулахад хүндрэлтэй байдаг гэж судлаачид үздэг. Эрүүл мэндийн бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг хувийн байгууллагад тусгай эрх олгож, итгэл хүлээлгэж байгаа нь эргээд төрийн байгууллагын нэр хүндэд муугаар нөлөөлөх эрсдэлтэй. Цаашлаад, төр хувийн хэвшил түншилж эхэлснээр аливаа хувийн байгууллага тухайн институцийг бүхлээр нь “атгадаг” болох буюу хүн амын эрүүл мэндийн хамгаалахад чиглэсэн зохицуулах арга хэмжээ, татвар гэх мэтээс зайлсхийх, засгийн газарт нөлөөтэй болох зэрэг сөрөг үр дагаврууд гарч болно.

Эрүүл мэндийг дэмжих үйл ажиллагаа, үйлчилгээ нийлүүлэх хоёр нь худалдааны ашиг сонирхлын хувьд хоёр өөр ажил юм. Эрүүл мэндийг дэмжих үйл ажиллагаа гэдэгт хүн амыг эрүүл мэндээ илүү сайн хянаж сургахад чиглэсэн нийгмийн болоод хүрээлэн буй орчны асуудлуудыг хамарсан бодлого боловсруулж, хүн амын эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлж, улмаар орчиндоо өөрчлөлт хийх, эрүүл амьдралын хэв маягийг дадал болгох ажлууд багтана. Гэтэл эдгээр ажлуудын зарим нь бизнесийн загваруудтай зөрчилдөж байдаг.

Төрийн байгууллага хувийн хэвшилтэй түншлэлийн гэрээ байгуулахынхаа өмнө тухайн аж ахуйн нэгж нь эрүүл мэндэд сөрөг нөлөөтэй бараа бүтээгдэхүүнийг сурталчилж борлуулдаг эсэхийг харж байж сонголтоо хийх нь зүйтэй гэж зарим судлаачид зөвлөдөг. Тэгвэл эрүүл мэндэд сөргөөр нөлөөлдөг гэлцдэг алкохол, хэт боловсруулсан хоол хүнсний сөрөг нөлөөг төрөөс ямар нэг журмаар тогтоогоогүй бол ямар баримтаар сөрөг нөлөөтэй гэж нотлох вэ гэсэн асуудал гарч ирнэ. Тэгвэл “Galea and McKee” хэмээх судалгааны институцээс төр хувийн хэвшлийн түншлэлийг эхлүүлэхдээ таван шалгуур тавьж байхыг бодлого боловсруулагчдад санал болгожээ. Хамгийн гол урьдач нөхцөл нь тухайн хувийн байгууллагын гол нэрийн бүтээгдэхүүн нь эрүүл мэндэд хортой байж болохгүй бөгөөд хувийн хэвшлийн түнш нь төрийн байгууллагаас эрхэлж байгаа үйл ажиллагааны зохион байгуулалтыг дэмжих маягаар оролцох болохоос бодлого төлөвлөж оролцож болохгүй. Стратеги төлөвлөлт нь төрийн байгууллагын ажил байх ёстой. Том корпорациудтай хамтарч ажиллахын сөрөг нөлөөг сүүлийн үед аль аль талдаа хүлээн зөвшөөрөх болсон. Жишээлбэл Global Fund нь Африкийн орнуудад төсөл хэрэгжүүлэхдээ Heineken-тэй хамтарч ажилласан нь иргэний нийгмийн зүгээс маш том эсэргүүцэлтэй нүүр тулсан учраас хамтын ажиллагаа цуцлахаас аргагүйд хүрсэн. Нөлөө талаас хэрвээ эрүүл мэндэд ямар ч хоргүй бүтээгдэхүүн үйлдвэрлэж, борлуулдаг байгууллагатай л хамтарч ажиллана гэсэн шаардлага тавих юм бол бараг бүх боломжит түншүүд улаан шугамны доор орж, даян дэлхийн эрүүл мэндийн зорилтуудыг хэрэгжүүлэх үйлс урагшгүй болно гэж зарим судлаачид маргадаг. Харин оронд нь арай боломжийн, гэхдээ илүү нарийн тодорхой шалгууруудыг боловсруулж тавих шаардлагатай гэж тэд үзэж байна.

Мөн эрүүл мэндийг дэмжих үйл ажиллагаанд түншлэх хувийн байгууллагад тавигдах шаардлагыг боловсруулахаас илүүтэй, тухайн байгууллагатай түншилвэл үр ашигтай гэсэн баталгааг шинжлэх ухааны судалгаагаар хэрхэн нотлох нь төвөгтэй асуудал болдог. Угтаа бол үнэлгээг хийхдээ тухайн байгууллага ямар байгууллага вэ гэдэгт биш тухайн байгууллагатай түншилснээр хүн амын эрүүл мэндэд бодитой, урт хугацааны эерэг өөрчлөлт гарч чадах уу гэдэг анхаарах хэрэгтэй юм. Эрүүл мэндийн үзүүлэлтээр энэ өөрчлөлтийг хэмжихэд ярвигтай боловч эрүүл мэндийг дэмжих үйл ажиллагаа хэрэгжиж эхлэхээс өмнөх үнэлгээг хийхэд зориулан дунд шатны шалгуур үзүүлэлтүүдийг боловсруулсан байдаг тул тэдгээр үзүүлэлтүүдээ дахин хэмжихэд өөрчлөлтийг хэмжиж болохоор байгаа юм. Одоогийн байдлаар хийгдсэн байгаа судалгаанууд нь эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэх асуудлаар төр ба хувийн хэвшлийн хооронд байгуулсан гэрээг, эсвэл тухайн төр хувийн хэвшлийн түншлэлийн шинж чанарыг үйл явцынх нь хүрээнд судлах зэргээр л хязгаарлагдаж байгаа юм. Тухайн түншлэлийн үр дүнд хүн амын эрүүл мэнд сайжирсан эсэхийг судалсан судалгаа одоогоор байхгүй байна гэсэн үг.

Аргачлал

Хүн амын эрүүл мэндийг дэмжихэд чиглэсэн төр хувийн хэвшлийн түншлэлийн үйл явц, үр ашгийг үнэлсэн шинжлэх ухааны судалгааны тайлангуудыг олохоор Medline, Web of Science датабаазад системтэйгээр хайлт хийж, хайлтад тавигдах шаардлагыг хэрэгжүүлсэн судалгаануудыг олж

тэдгээрийг чанарыг үнэлсэн. Төр хувийн хэвшлийн түншлэлүүдийг эрүүл мэндийн салбарын шийдвэрлэсэн асуудлаар нь болон түншилсэн хувийн байгууллагын бизнесийн сонирхол болон эрүүл мэндийг дэмжих тухайн үйл ажиллагааны хооронд зөрчил гарах магадлал зэргийг харгалзан үнэлгээний дүгнэлтүүдийг эерэг (дэмжигдэх/дэмжигдэж болохуйц), сөрөг (хагас шүүмжлэгдэхүйц/шүүмжлэгдэх) гэж ангилсан.

Үр дүн

Судалгааны баг 25 Төр хувийн хэвшлийн түншлэлд хийсэн 36 судалгааг олж илрүүлсэн. Эрүүл мэндийн салбарт төр хувийн хэвшлийн түншлэлийг хэрэгжүүлэх нь зүйтэй бөгөөд үр ашигтай гэж үнэлсэн үнэлгээнүүдийг хянаж үзэхэд аль нэг талаас хараат, эсвэл чанаргүй үнэлгээний ажлууд байна. Нөгөө талаар, сөрөг үнэлгээнүүд нь төр хувийн хэвшлийн түншлэлд оролцсон хувийн байгууллага нь эрүүл мэндийг дэмжих үйл ажиллагаа болон хувийн санхүүгийн ашиг сонирхлын хооронд зөрчилтэй байх өндөр магадлалтай байгууллагууд оролцсон судалгаа байсан. Халдварт өвчин болон эрүүл мэндийн бусад асуудал руу чиглэсэн үйл ажиллагаа явуулсан төр хувийн хэвшлийн түншлэлээс илүү халдварт бус өвчний асуудлаар үйл ажиллагаа явуулсан төр хувийн хэвшлийн түншлэлүүд сөрөг үнэлгээ авсан нь харагдаж байна. Бараг бүх үнэлгээний ажлууд үйл явцыг үнэлсэн байсан бол зөвхөн хоёрхон үнэлгээний ажил л эрүүл мэндэд гарсан үр өгөөжийн асуудлаар тоо баримттай судалгаа хийсэн байна.

Дүгнэлт

Эрүүл мэндийн дэмжих асуудлаарх төр хувийн хэвшлийн түншлэл нь үр ашигтай гэсэн тодорхой нотолгоо хангалтгүй байсаар байна. Нотолгоо байсан ч гэсэн “хараат бус” үнэлээчид тэдгээрийг эргэлзээтэй гэж үзэж байна. Эрүүл мэндийг дэмжих тухайн үйл ажиллагаатай зөрчилдөхөөр ашиг сонирхол бүхий хувийн байгууллагатай гэрээ байгуулахаас аль болох зайлсхийх нь төрийн байгууллагын хувьд санавал зохих зүйл болж байна.

Баримт нотолгоо

- [Lucy A. Parker](#),
- [Gustavo A. Zaragoza](#) &
- [Ildefonso Hernández-Aguado](#)
- [BMC Public Health](#) **volume 19**, Article number: 1438 (2019)
- [Cite this article](#) **3489** Accesses **18** Altmetric [Metricsdetails](#)